

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 01 дүгээр  
сарын 27-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Г “Баянцогт нуур” хоршооны хадгаламж, зээлийн Ү  
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг  
түдгэлзүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.4, 13.1; Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Баянцогт нуур” хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2. Түдгэлзүүлсэн хугацаанд Хорооноос өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангаж ажиллаагүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохыг “Баянцогт нуур” хоршоо /Л.Насанбаяр/ -нд анхааруулсугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН